



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮНИЙ  
АСУУЛТ

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг  
Жанжин Д.Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон  
Утас: 26-70-16, Факс: 32-70-16  
E-mail: [stategreathural@parliament.mn](mailto:stategreathural@parliament.mn)  
<http://www.parliament.mn>

2026.04.30 № 23

Жеффри Эпштэйнтэй холбоотой материал  
болон Монгол Улсын эрх ашигт холбогдох  
асуудлыг тодруулах тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.13, 37 дугаар зүйлийн 37.1.1 дэх заалт, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсгийг тус тус үндэслэн Танд дараах асуултыг тавьж байна.

Америкийн Нэгдсэн Улсад насанд хүрээгүй хүнийг бэлгийн мөлжлөгт татан оролцуулсан хэрэгт ял шийтгүүлж, улмаар хүн худалдаалах, бэлгийн мөлжлөгийн хэрэгт дахин шалгагдаж байх явцдаа нас барсан Жеффри Эпштэйн (Jeffrey Epstein) Монгол Улсын Ерөнхийлөгч, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн даргаар ажиллаж байсан хүмүүстэй ойр дотно харилцаатай байсан төдийгүй Монгол Улсын стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын орд газруудыг ашиглах, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой томоохон уул уурхайн компаниуд болох “Эрдэнэт” уулын баяжуулах үйлдвэр, Оюу Толгой болон бусад ордуудтай холбоотой шийдвэр гаргалтад нөлөөлсөн байж болзошгүй тухай мэдээлэл олон улсын хэвлэл мэдээллийн хэрэгслээр удаа дараа гарч байна.

Америкийн Нэгдсэн Улсын Конгрессоос 2025 оны 11 дүгээр сард баталсан “Эпштэйний хавтаст хэргийн ил тод байдлын тухай хууль” (Epstein Files Transparency Act)-ийн дагуу Америкийн Нэгдсэн Улсын Хууль зүйн яамнаас<sup>1</sup> болон Америкийн Нэгдсэн Улсын Конгрессын Төлөөлөгчдийн танхимын Хянан шалгах болон засаглалын реформын хорооноос<sup>2</sup> ил тод, нээлттэй болгосон хавтаст хэргийн материал, баримт бичиг (цаашид “Эпштэйний хавтаст хэрэг” гэх)-т Монгол Улсын төрийн өндөр албан тушаал хашиж байсан хувь хүмүүс олон удаа дурдагдсантай холбогдуулан Монгол Улсын төрийн өндөр албан тушаал хашиж байсан хувь хүмүүстэй Жеффри Эпштэйний тогтоосон албан болон албан бус хувийн харилцаа нь Монгол Улсын холбогдох хууль тогтоомж, гадаад харилцааны бодлого, үндэсний эрх ашигт нийцэж байсан эсэх, Жеффри Эпштэйн нь Монгол Улсын төрийн шийдвэр гаргах үйл ажиллагаанд зүй бусаар, хууль зөрчин нөлөөллийн үйл ажиллагаа явуулж байсан эсэх талаарх дэлгэрэнгүй мэдээллийг дараах асуудал тус бүрээр гаргаж ирүүлнэ үү!

1. Жеффри Эпштэйний хавтаст хэрэг ил тод, нээлттэй болсонтой холбогдуулан тухайн ил тод болсон материал, баримт бичигт дурдагдсан Монгол Улстай холбогдох асуудлууд болон олон улсын хэвлэл мэдээллийн хэрэгслээр гарсан мэдээлэлтэй холбогдуулж Монгол Улсын Ерөнхийлөгч асан Ц.Элбэгдорж, Х.Баттулга нар түүнтэй тус бүр хэдэн удаагийн уулзалт хийсэн тухай мэдээллийг нягтлах шаардлагатай гэж үзэж байна. Тухайлбал;

<sup>1</sup> Америкийн Нэгдсэн Улсын Хууль зүйн яамнаас ил тод, нээлттэй болгосон хавтаст хэргийн материал, баримт бичгүүдтэй танилцах холбоос: <https://www.justice.gov/epstein>

<sup>2</sup> Америкийн Нэгдсэн Улсын Конгрессын Төлөөлөгчдийн танхимын Хянан шалгах болон засаглалын шинэчлэлийн хорооноос ил тод, нээлттэй хавтаст хэргийн материал, баримт бичгүүдтэй танилцах холбоос: <https://oversight.house.gov/release/oversight-committee-releases-epstein-records-provided-by-the-department-of-justice/>

- Жеффри Эпштэйн Монгол Улсын гадаад бодлого болон үндэсний язгуур эрх ашигтай холбоотой асуудлаар Монгол Улсын төрийн өндөр албан тушаал хашиж байсан хувь хүмүүс (тухайлбал Монгол Улсын Ерөнхийлөгч асан Ц.Элбэгдорж, Х.Баттулга, Гадаад хэргийн сайд асан Л.Пүрэвсүрэн, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн нарийн бичгийн дарга асан Ц.Энхтүвшин зэрэг)-тэй албан болон албан бус холбоо тогтоож, зөвлөгөө өгч байсан эсэх;
- Жеффри Эпштэйн Монгол Улстай холбоотой хийж байсан ажил, үйл ажиллагааны талаар Гадаад харилцааны яам зэрэг холбогдох төрийн байгууллага тухай бүрд нь мэдээлэл авч байсан эсэх;
- Насанд хүрээгүй хүүхдийг хүний наймаа, бэлгийн мөлжлөгт зуучилж байсан Жеффри Эпштэйний хууль бус ажиллагаанд Монгол Улсын иргэн хохирогч болсон эсэх, ил тод, нээлттэй болгосон “Эпштэйний хавтаст хэрэг” цахим архивд ([www.justice.gov/epstein](http://www.justice.gov/epstein)) нэр дурдагдсан Монгол Улсын иргэдийн дунд насанд хүрээгүй хүүхэд байсан эсэх;
- Насанд хүрээгүй хүнийг бэлгийн мөлжлөгт татан оролцуулсан хэрэгт ял шийтгүүлж, улмаар хүн худалдаалах, бэлгийн мөлжлөгийн хэрэгт дахин шалгагдаж байсан Жеффри Эпштэинтэй хувийн харилцаатай байсан гадаадын хэд хэдэн улсын төрийн өндөр албан тушаал хашиж байсан хүмүүс албан тушаалаасаа огцорч, холбогдох журмын дагуу одоо ч шалгагдаж байгаатай холбогдуулан Жеффри Эпштэинтэй Монгол Улсын Ерөнхийлөгч асан Ц.Элбэгдорж, Х.Баттулга нар хувийн харилцаа тогтоож байсан нь Монгол Улсын эрх ашгийг зөрчсөн эсэх;

2. Монгол Улсын Ерөнхийлөгч асан Ц.Элбэгдорж Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий Ассамблейн жилийн чуулга уулзалтад оролцох үедээ 2013, 2014 онд Америкийн Нэгдсэн Улсын Нью-Йорк хот дахь Жеффри Эпштэйний гэрт уулзалт хийсэн байж болзошгүй талаарх баримт, мэдээлэл ил болсонтой холбогдуулж тус уулзалтын талаар болон уулзалтын мөрөөр хэрэгжүүлсэн арга хэмжээ, үйл ажиллагааны талаарх дэлгэрэнгүй мэдээлэл. Үүнд:

- Монгол Улсын Ерөнхийлөгч асан Ц.Элбэгдорж, Гадаад хэргийн сайд асан Л.Пүрэвсүрэн нарын Жеффри Эпштэинтэй хийсэн уулзалт (Жеффри Эпштэйний гэрт татуулсан зургаар нотлогдсон гэх) тухайн үеийн албан ёсны айлчлалын хөтөлбөрт багтсан эсэх, албан протоколын дагуу болсон эсэх, уулзалтын талаар Гадаад харилцааны яаманд мэдэгдсэн эсэх;
- Монгол Улсын Ерөнхийлөгч асан Ц.Элбэгдорж Швейцарын Холбооны Улсын Давос хотноо Дэлхийн эдийн засгийн форумд оролцохдоо Жеффри Эпштэинтэй болон түүнтэй холбож танилцуулсан хүмүүстэй уулзалт хийсэн эсэх;
- Монгол Улсын Ерөнхийлөгч асан Ц.Элбэгдоржид зөвлөгөө өгөх зорилгоор байгуулагдсан Олон улсын зөвлөхүүдийн зөвлөл (International Advisory Board)-ийн бүрэлдэхүүн, үйл ажиллагаа, зардал, хийсэн ажлын үр дүн, бусад асуудлын талаар Гадаад харилцааны яам болон төрийн бусад байгууллага мэдээлэлтэй байсан эсэх, холбогдох журмын дагуу гэрээ байгуулсан эсэх, зөвлөх тус бүрд олгосон гэх 100,000 ам.долларын үйлчилгээний хөлсийг улсын төсвөөс санхүүжүүлсэн эсэх;
- Жеффри Эпштэйн болон Олон улсын зөвлөхүүдийн зөвлөлийн бүрэлдэхүүнд орсон зөвлөхүүд (тухайлбал Ларри Саммерс, Кэвин Рудд гэх мэт) Монгол Улсад ирж байсан эсэх;
- Жеффри Эпштэйн болон Олон улсын зөвлөхүүдийн зөвлөл Монгол Улсын эдийн засагт нөлөөлөх томоохон төслүүд болох “Эрдэнэт” уулын баяжуулах үйлдвэр, Оюу Толгой зэрэг томоохон төслүүдтэй (тухайлбал, Оюу Толгой төслийн Далд уурхайн

бүтээн байгуулалт, санхүүжилтийн төлөвлөгөө, далд уурхайн санхүүжилтийн асуудал зэрэг) холбогдуулж зөвлөгөө өгч, Засгийн газрын болон төрийн холбогдох байгууллагын шийдвэр гаргах үйл ажиллагаанд нөлөөлж байсан эсэх;

- Монгол Улсын стратегийн орд газар болон үүсмэл ордуудыг ашиглах тухай нэр бүхий байгууллагуудаас бэлдсэн танилцуулгад дурдагдсан төслүүд хэрэгжсэн эсэх, эдгээр төслүүдийн санхүүгийн харилцан хамаарлын тухай, хууль хяналтын байгууллагаар шалгагдан тогтоогдож байсан цаглавар зэрэг санхүүгийн дансны гүйлгээнүүд хамааралтай эсэх;

3. Жеффри Эпштэйн нь Монгол Улс, Израил Улсын хооронд аюулгүй байдлын асуудлаар хамтран ажиллах гэрээ байгуулахад зуучилсан гэх мэдээлэл Израилын Ерөнхий сайд асан Эхуд Барак (Ehud Barak) болон Жеффри Эпштэйн нарын захидал харилцаанд дурдагдсан байгаа учир энэхүү хамтран ажиллах асуудал нь холбогдох хууль тогтоомжийн дагуу судлагдаж, зөвшөөрөл авсан эсэх талаарх дэлгэрэнгүй мэдээлэл. Үүнд:

- Израил Улсын Ерөнхий сайд асан Эхуд Барак Монгол Улсад ирж байсан эсэх талаар мэдээлэл гарч буйтай холбогдуулан хэзээ, хэдэн удаа ирсэн талаарх мэдээлэл;
- Израил Улсын Ерөнхий сайд асан Эхуд Барак Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн нарийн бичгийн даргаар ажиллаж байсан Ц.Энхтүвшинд гар буу бэлэглэж байсан гэх мэдээлэл гарсантай холбогдуулан гар бууг хилээр нэвтрүүлэх зөвшөөрөл зохих журмын дагуу олгогдож, холбогдох бүртгэлийг хийлгэсэн эсэх талаарх мэдээлэл;
- Монгол Улс, Израил Улсын хооронд аюулгүй байдлын асуудлаар байгуулсан хамтын ажиллагааны гэрээний агуулга, холбогдох мэдээлэл;

4. Монгол Улсын Гадаад хэргийн сайд, Монгол Улсын Ерөнхийлөгчийн зөвлөх асан Л.Пүрэвсүрэн нь Жеффри Эпштэинтэй цахим шуудангаар харилцаж, тогтмол уулзсан гэх мэдээлэлтэй холбогдуулж дараах асуудлаар дэлгэрэнгүй мэдээлэл. Үүнд:

- Монгол Улсын Гадаад харилцааны яам Жеффри Эпштэинд зөвлөх үйлчилгээний төлбөр төлж байсан эсэх;
- Монгол Улсын Гадаад харилцааны яам Жеффри Эпштэйн болон Олон улсын зөвлөхүүдийн зөвлөлд багтсан хувь хүмүүсээр дамжуулан гадаад улсын төрийн байгууллага болон хувь хүмүүстэй уулзалт зохион байгуулж байсан эсэх;
- Монгол Улсын Гадаад хэргийн сайдаар ажиллаж байсан Л.Пүрэвсүрэн албан хэрэгцээнд хувийн цахим шуудан хаяг ашиглаж байсан эсэх, албаны болон хувийн цахим шуудан ашиглахтай холбогдуулж Гадаад харилцааны яам тодорхой бодлого хэрэгжүүлж, хяналт тавьдаг байсан эсэх;

5. Жеффри Эпштэйн зуучилсны дагуу Монгол Улсын Гадаад харилцааны яам (тухайн үед Гадаад хэргийн яам) болон Олон улсын энх тайвны хүрээлэн (International Peace Institute) хооронд харилцан ойлголцлын санамж бичигт гарын үсэг зурж, хамтарч ажилласан гэх мэдээлэл гарсантай холбогдуулж дараах асуудлаар дэлгэрэнгүй мэдээлэл. Үүнд:

- 2013 онд болон түүний дараа Олон улсын энх тайвны хүрээлэнтэй байгуулсан санамж бичиг, хамтын ажиллагааны талаарх мэдээлэл;
- Олон улсын энх тайвны хүрээлэнгийн төлөөлөл Монгол Улсад ажлын томилолтоор ирж байсан тухай дэлгэрэнгүй мэдээлэл, хөтөлбөр;

- Олон улсын энх тайвны хүрээлэнгээс ирүүлсэн тайлан, зөвлөмж, мэдээлэл;

6. Жеффри Эпштэйнтэй хувийн харилцаа сайтай байсан төдийгүй санхүүжилт авдаг байсан гэх Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Хаант Улсын хунтайж асан Эндрью Маунтбаттэн-Виндзор болон Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Хаант Улсын парламентын Лордын танхимын гишүүн асан Ричард Мэнделсон нар нь Монгол Улсын эдийн засгийн ач холбогдол бүхий томоохон стратегийн ордууд, бизнесийн ашиг сонирхолтой холбоотой асуудлаар тодорхой үйл ажиллагаа явуулж байсан эсэх талаарх дэлгэрэнгүй мэдээлэл. Үүнд:

- Эндрью Маунтбаттэн-Виндзор болон Ричард Мэнделсон нар Монгол Улсад ирж байсан эсэх, ирж байсан бол хэзээ, хэдэн удаа ирж байсан талаарх мэдээлэл;
- Эндрью Маунтбаттэн-Виндзор болон Ричард Мэнделсон нар Монгол Улсын төрийн байгууллагуудын төлөөлөлтэй уулзалт хийж байсан эсэх;
- Монгол Улсын төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгжүүд олон улсын санхүүгийн зөвлөх үйлчилгээний компани болох Лазард (Lazard)-тай зөвлөх үйлчилгээний гэрээ байгуулж, зөвлөгөө авч байсан эсэх;

7. Жеффри Эпштэйнтэй хувийн харилцаа сайтай байсан гэх Арианэ Дэ Ротшильд (Ariane De Rothschild) Монгол Улсын эдийн засгийн ач холбогдолтой томоохон стратегийн ордууд, бизнесийн ашиг сонирхолтой холбогдуулж тодорхой үйл ажиллагаа явуулж байсан эсэх талаарх дэлгэрэнгүй мэдээлэл. Үүнд:

- Арианэ Дэ Ротшильд Монгол Улсад ирж байсан эсэх мэдээлэл;
- Арианэ Дэ Ротшильд Монгол Улсын төрийн байгууллагууд, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой "Эрдэнэт" уулын баяжуулах үйлдвэр, Оюу Толгой ХХК, Эрдэнэс Оюу Толгой ХХК зэрэг компаниудтай уулзалт зохион байгуулж байсан эсэх;
- Монгол Улсын төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой "Эрдэнэт" уулын баяжуулах үйлдвэр, Оюу Толгой ХХК, Эрдэнэс Оюу Толгой ХХК зэрэг компаниуд Арианэ Дэ Ротшильдын хамаарал бүхий банк, хуулийн этгээдүүдтэй хамтран ажиллаж байсан, зөвлөх үйлчилгээ авч байсан болон төлбөр төлсөн эсэх.

Эдгээр асуултын хариуг Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2 дахь хэсэгт заасан хугацаанд ирүүлэхийг хүсье.

Хүндэтгэсэн,

УЛСЫН ИХ ХУРЛЫН  
ГИШҮҮН



Л.ОЮУН-ЭРДЭНЭ

3026000065